



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 6/04

Мандалговь

Д.Очбадрахыг албан тушаалд томилох тухай<sup>1</sup>

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 50 дугаар зүйлийн 50.1 дахь заалт, Авлигатай тэмцэх газрын 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 05/590 тоот албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дагдангийн Очбадрахыг Дундговь аймгийн Хот тохижуулах Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын даргаар 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн томилон ажиллуулсугай.

2. Д.Очбадрахын албан тушаалын цалинг Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс тогтоосон шийдвэрийн дагуу олгохыг Хот тохижуулах Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

3. "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан хориглолт, хязгаарлалтыг баримтлан, ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж, төрийн бодлого, шийдвэр, хууль, тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэн, албан тушаалын чиг үүргийн дагуу ажилдаа хариуцлага, санаачилгатай хандан, төрийн үйлчилгээг чанартай зохион байгуулж, төрийн албан хаагчийн ёс зүйг мөрдөн ажиллахыг Хот тохижуулах Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга (Д.Очбадрах)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4823110072